

**Агуулга**

<b>I. НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ТУХАЙ.....</b>	<b>3</b>
<b>II. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙ .....</b>	<b>4</b>
<b>1. Алсын хараа.....</b>	<b>4</b>
Эрхэм зорилго.....	5
<b>2. ДСБА шинжилгээ .....</b>	<b>5</b>
<b>3. Амжилтын хүчин зүйлүүд.....</b>	<b>6</b>
<b>4. Хэрэгжүүлэх алхамууд .....</b>	<b>7</b>
Зураглал.....	8
<b>III. ХАМРАХ ХҮРЭЭ, .....</b>	<b>8</b>
Эрсдэлийн үнэлгээ.....	9
Аудитын төрөл .....	9


ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ДСБА	Давуу талууд, сул талууд, боломжууд, аюулууд
НЗД	Нийслэлийн Засаг дарга
ОНӨТҮГ	Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар

## I. НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ТУХАЙ

Нийслэлийн Дотоод аудитын алба Нийслэлийн Засаг даргын 2014 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн А/156 дугаар захирамжаар анх байгуулагдаж, 2016 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн А/830 дугаар захирамжаар дүрмийг шинэчлэн баталсан. Дүрмийн 1.1-т “*Нийслэлийн дотоод аудитын алба /цаашид алба гэх/ нь Засагийн газрын болон Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилтуудыг хэрэгжүүлэх, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын эрсдлийн удирдлага, засаглал, дотоод хяналт, санхүүгийн үйл явцыг үнэлж, дүгнэлт, зөвлөмж өгөх, үйл ажиллагааг нь сайжруулахад дэмжлэг үзүүлэх үндсэн үүрэг бүхий Нийслэлийн засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг мөн.*” хэмээн тус албаны үйл ажиллагааны чиг үүргийг тодорхойлжээ.

### Албаны удирдлага, бүтэц зохион байгуулалт



Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 09 дүгээр сарын 29 –ны өдрийн 3/08 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т засаглалыг бэхжүүлэх талаар “*Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас үзүүлж байгаа төрийн үйлчилгээнд шинэ менежмент нэвтрүүлэх, мэдээллийн технологийн ухаалаг шийдлүүдийг ашиглах, төрийн албан хаагчийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, хариуцлагыг дээшлүүлэх замаар төрийн үйлчилгээг иргэдэд цогц, хүртээмжтэй, ШУУРХАЙ, ТЭГШ, НЭЭЛТТЭЙ хүргэнэ.*” хэмээн заасан ба нийслэлийн Дотоод аудитын албаны үйл ажиллагаатай шууд хамааралтай дараах заалтууд тусгагдсан байна. Үүнд:

5.3.9 Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд тавих хяналтыг тогтмолжуулж, ажлын хариуцлага, уялдаа холбоог эрс сайжруулна.

5.3.11 Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдүүлж хэвшүүлнэ.

5.3.12 Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод хяналтыг сайжруулах замаар ажлын байрны эмх цэгц, үүрэг хариуцлагыг дээшлүүлэх тогтолцоонд бүрэн шилжүүлнэ.

## II. СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙ

Нийслэлийн дотоод аудитын албаны энэхүү стратеги төлөвлөгөө нь Санхүү, эдийн засгийн сайдын 2003 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 93 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн байгууллагын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө боловсруулах заавар”, Олон улсын Дотоод аудиторчуудын институтээс хэвлэн гаргасан “Дотоод аудитын стратеги төлөвлөгөөг хөгжүүлэх нь” практик зөвлөмж болон PWC аудитын компанийн Дотоод аудитын мэргэжлийн судалгааны төвөөс боловсруулсан “Дотоод аудитын стратеги төлөвлөгөө нь дотоод аудитын алсын харааг хурдацтай шилжилтийн үед бодит болгох нь” зөвлөмж хэвлэлийн агуулгын хүрээнд боловсруулагдсан болно.

Стратеги төлөвлөгөө нь 2017-2020 оныг хамрах ба алсын хараа, эрхэм зорилго, зорилтуудыг тодорхойлон тусгасан. Стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа ДСБА /SWOT/ шинжилгээг суурь болгож, албаны алсын хараа, эрхэм зорилгыг хэрэгжүүлэхэд ямар хүчин зүйлүүд тулгарах, тэдгээрт ямар хариу арга хэмжээг авах талаар судлан тодорхойлсон бөгөөд дараах үе шатаар боловсруулсан.



### 1. Алсын хараа

Дотоод аудитын мэргэжлийн практикийн олон улсын стандартуудын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж, гадны сайн туршлагыг нэвтрүүлсэн, Монгол улсын болон бүс нутгийн хэмжээнд улсын салбарын дотоод аудитын үйл ажиллагааны үр дүн, чанараар тэргүүлэгч хамт олон болох.

#### Дотоод аудиторын алсын хараа



Эрхэм зорилго

Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагуудын эрсдэлийн удирдлага, засаглал, дотоод хяналтын үйл явцыг хараат бус, бие даасан байдлаар үнэлэн дүгнэлт, зөвлөмж өгч, үйл ажиллагааг сайжруулахад оршино.



2. ДСБА шинжилгээ

ДСБА шинжилгээгээр байгууллагын стратегид нөлөөлөх дотоод, гадаад хүчин зүйлүүдийг дараах нөхцлүүдтэй уялдуулан тодорхойлсон болно. Үүнд:

- ✧ Байгууллагын бүтэц
- ✧ Нөөцийн шаардлагууд
- ✧ Техник технологи
- ✧ Хамтын ажиллагаа (бусад эрсдлийн удирдлага, баталгаажуулалтын байгууллагуудтай)
- ✧ Дотоод аудитын үйлчилгээг үзүүлэх арга хэрэгсэл
- ✧ ТЕЗ, дотоод аудитын хороотой харилцах харилцаа
- ✧ Хүний нөөцийн хөгжүүлэлт
- ✧ Гүйцэтгэлийн үр дүн

	ДАВУУ ТАЛУУД	СУЛ ТАЛУУД
Дотоод	1 Дотоод аудитын алсын хараа, зорилго тодорхойлогдсон	1 Эрсдэлд суурилсан дотоод аудит хийх тохирсон аргачлалгүй
	2 Аудитад хамрагдах байгууллагууд, объектууд тодорхой	2 Хүний нөөцийн хөгжлийн тодорхой загваргүй
	3 Тодорхой хэмжээний аудитын туршлагатай албан хаагчидтай	3 Албан хаагчдын албан тушаал дэвших боломж хязгаартай - авьяас чадварт үндэслэгддэггүй
	4 Санхүү, нягтлан бодох бүртгэлээр мэргэшсэн албан хаагчид их	4 Үр дүнтэй, үр нөлөөтэй үйл ажиллагаанд тавих анхаарал хязгаарлагдмал
	5 Аудитыг гүйцэтгэхэд шаардагдах компьютер, техник хэрэгсэлтэй	5 Байгууллагын стратегид эрсдлийн үнэлгээ хийгдээгүй
	6 Дотоод аудитын олон улсын стандартыг бүрэн мөрддөггүй	
	7 Санхүү, нягтлан бодох бүртгэлээс бусад чиглэлээр мэргэшсэн албан хаагчгүй	
	8 Албан хаагчид зохих ёсны өөрчлөлт, шинэчлэлтэд сөрөг хандлагатай, стратегийн дагуу нэг зүгт тэмүүлдэггүй	
	9 Аудитын объектуудтай харьцуулахад хүний нөөц дутмаг	
	10 ТЕЗ, дотоод аудитын хороо эрсдэлд бус санхүүгийн болон нийцлийн зүйлд хэт их анхаарах	
	БОЛОМЖУУД	АЮУЛУУД
Гадаад	1 Албан хаагчдын мэдлэг, ур чадвар, багтааж нэмэгдэх	1 Аудитын үйл ажиллагаа төсөв, хүний нөөц, засаглалын хүрээнд хязгаарлагдах
	2 ТЕЗ, дотоод аудитын хорооны гишүүдэд дотоод аудитын үүрэг, мөн чанар, ач холбогдлыг ойлгуулах	2 ТЕЗ, дотоод аудитын хорооны гишүүд болон хамрах хүрээний байгууллагуудын удирдлагуудтай хамтын ажиллагаа буурах
	3 Шинэ зорилтууд, арга хэмжээнүүдийг цаг алдалгүй хяналтын хэсэг болгох	3 Төлөвлөгөөт бус аудит их хэмжээгээр захиалагдаж төлөвлөгөөт аудитын чанарын болон тоон үзүүлэлт, байгууллагын стратегид сөргөөр нөлөөлөх
	4 Эрсдэлийн үнэлгээ, хяналтыг баталгаажуулагч байгууллагуудтай хамтарч ажиллах	4 Өөрчлөгдөн буй эрсдэлүүд ур чадварыг илүү шаардах
	5 Эрсдэл, дотоод хяналтын үнэлгээний загвар танилцуулагдах	5 Хууль, эрх зүйн орчин нь дотоод аудитын олон улсын стандарт, сайн туршлагын дагуу боловсронгуй болохгүй байх



### 3. Амжилтын хүчин зүйлүүд

#### Байгууллагын хамгийн өндөр эрсдэлтэй хэсгүүдэд анхаарах

Арга зам: Байгууллагын стратегийн, үйл ажиллагааны, санхүүгийн болон хяналтын эрсдлүүдийг төлөвлөлтийн үе шатанд тодорхойлж байхаар сайжруулах.

ДСБА шинжилгээнд: Сул талууд – 5, 9  
Боломжууд – 3, 4

Зорилт 1: Байгууллагын стратегийг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж болох дотоод, гадаад эрсдэлүүдийг тодорхойлох, үнэлэх, бууруулах үйл явцыг тасралтгүйгээр хэрэгжүүлэх.

#### ТЕЗ, хороонд нөлөөлөхүйц тайлагнах

Арга зам: Дотоод аудитын үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулж, ТЕЗ, хорооны гишүүдтэй эрсдэл, аудитаар илэрсэн зөрчлүүд, асуудлын шийдлийн хүчин чармайлтын талаар зөв цагт, үр нөлөөтэй харилцах.

ДСБА шинжилгээнд: Сул талууд – 10  
Боломжууд – 2

Зорилт 2: ТЕЗ болон дотоод аудитын хороог аудитын үнэн бодитой мэдээллээр хангах замаар дотоод аудитын мөн чанар, үр нөлөө, үр ашигтай байдлыг таниулах.

#### Аудитын үйл явцыг ямагт үр нөлөөтэй, үр ашигтайгаар явуулах

Арга зам: Дотоод аудитын бүх баталгаажуулах, зөвлөх үйлчилгээг гүйцэтгэхдээ ашиглах аргачлалыг тодорхойлж хөгжүүлэх.

ДСБА шинжилгээнд: Сул талууд – 1, 3, 4, 6  
Боломжууд – 5

Зорилт 3: Аудитын төрлүүд болон байгууллагуудын онцлогт тохирсон аудит хийх аргачлалыг Дотоод аудитын мэргэжлийн практикын олон улсын стандартууд, Санхүүгийн хяналт шалгалтын стандартын хүрээнд боловсруулан, мөрдөж ажиллах.

#### Ур чадвар, мэдлэг, туршлага, эерэг хандлагатай албан хаагчдыг дэмжих

Арга зам: Чухал шаардлагатай ур чадварыг тодорхойлон хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, зорилгыг хэрэгжүүлэх стратегийн боломжуудыг хөгжүүлэх.

ДСБА шинжилгээнд: Сул талууд – 2, 3, 6, 7, 8  
Боломжууд – 1

Зорилт 4: Аудитыг үр өгөөжтэй, чанартай гүйцэтгэхэд шаардлагатай нөөцүүдийг оновчтой удирдаж, байгууллагын хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангах.



#### 4. Хэрэгжүүлэх алхамууд

Стратеги төлөвлөгөөг боловсруулах 3 дугаар үе шат буюу “Амжилтын хүчин зүйлүүд”-ээс тодорхойлогдсон 4 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ёстой дараах түлхүүр алхамуудыг тодорхойлж байна.

#	Зорилт	Түлхүүр алхам	Хүрэх үр дүн
1	Байгууллагын стратегийг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж болох дотоод, гадаад эрсдэлүүдийг тодорхойлох, үнэлэх, бууруулах үйл явцыг тасралтгүйгээр хэрэгжүүлэх.	Аудитын хамрах хүрээний байгууллагуудыг тодорхойлж, эрсдэлийг харьцуулсан байдлаар үнэлэх.	Эрсдэлийн үнэлгээний дагуу их эрсдэлтэй байгууллагууд богино хугацаанд аудитад хамрагдсан байна.
		Дунд болон богино хугацаанд аудитад хамрагдах объектуудыг нөөцийн хүрэлцээтэй байдал, мөн бусад хүчин зүйлстэй уялдуулан тодорхойлох.	Нөөцийг зөв хуваарилж, аудитыг үр нөлөөтэй хэрэгжүүлсэн байна.
		Бусад дотоод болон хөндлөнгийн аудитын байгууллагуудтай хамтарч ажиллах, хамтарсан аудит хийх болон үйл ажиллагааны төлөвлөгөөгөө харилцан уялдаатай боловсруулж хэрэгжүүлэх боломжийг судлах.	Бусад дотоод болон хөндлөнгийн аудитын байгууллагуудтай үр дүнтэй хамтран ажиллаж, аудитын үр өгөөж нэмэгдсэн байна.
2	ТЕЗ болон дотоод аудитын хороог аудитын үнэн бодитой мэдээллээр хангах замаар дотоод аудитын мөн чанар, үр нөлөө, үр ашигтай байдлыг таниулах.	Дотоод аудитын үйл ажиллагааны зорилго, чиг үүрэг, онцлог чанаруудыг дотоод аудитын хорооны хурал, аудитын гүйцэтгэх удирдлагад танилцуулах, тэднийг үр нөлөөтэй, үр ашигтай мэдээллээр хангаж албаны үнэ цэнийг нэмэгдүүлэх.	Улирал бүр аудитын хороонд стандартын дагуу хийгдсэн дотоод аудитын тайланг танилцуулж, удирдлагад дотоод аудитын үр нөлөө, үр ашгийг ойлгуулан, нийслэлийн хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн байна.
3	Аудитын төрлүүд болон байгууллагуудын онцлогт тохирсон аудит хийх аргачлалыг Дотоод аудитын мэргэжлийн практикын олон улсын стандартууд, Санхүүгийн хяналт шалгалтын стандартын хүрээнд боловсруулан, мөрдөж ажиллах.	Улсын салбарын дотоод аудитын чадавхийг бэхжүүлэх техникийн хамтын ажиллагааны төслийн хүрээнд боловсруулагдсан дотоод аудит хийх аргачлал, Сангийн сайдын 2016 оны 107 дугаар тушаалаар батлагдсан “Санхүүгийн хяналт шалгалтын стандарт”-ыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах, хянах үе шатуудад нэвтрүүлэх. Холбогдох ажлын баримтуудыг хөтлөх.	Дотоод аудит хийх аргачлал, санхүүгийн хяналт шалгалтын стандартын дагуу төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах, хянах үе шатуудад хөтлөгдөх ажлын баримтуудыг мөрдөж хэвшсэн байна.
4	Аудитыг үр өгөөжтэй, чанартай гүйцэтгэхэд шаардлагатай нөөцүүдийг оновчтой удирдаж, байгууллагын хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангах.	Олон улсын мэргэжлийн практикийн хүрээний дагуу дотоод аудит гүйцэтгэхэд шаардлагатай ёс зүй, мэдлэг, ур чадваруудыг тодорхойлон, байгууллагын хүний нөөцийн бодлого, албан хаагчдын сургалтын жил бүрийн төлөвлөгөөнд тусгуулан батлуулж, хэрэгжүүлэх.	Аудиторуудад сургалтын хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлон, сургалтын төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлснээр аудитын үр ашиг нэмэгдсэн байна.

## Зураглал

#	Түлхүүр алхамуудыг хэрэгжүүлэх хугацааны график	2017				2018				2019				2020				
		1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	1	2	3	4	
1	Аудитын хамрах хүрээний байгууллагуудыг тодорхойлж, эрсдэлийг харьцуулсан байдлаар үнэлэх.																	
2	Дунд болон богино хугацаанд аудитад хамрагдах объектуудыг нөөцийн хүрэлцээтэй байдал, мөн бусад хүчин зүйлстэй уялдуулан тодорхойлох.																	
3	Бусад дотоод болон хөндлөнгийн аудитын байгууллагуудтай хамтарч ажиллах, хамтарсан аудит хийх болон үйл ажиллагааны төлөвлөгөөгөө харилцан уялдаатай боловсруулж хэрэгжүүлэх боломжийг судлах.																	
4	Дотоод аудитын үйл ажиллагааны зорилго, чиг үүрэг, онцлог чанаруудыг дотоод аудитын хорооны хуралд танилцуулах, аудитын гүйцэтгэх удирдлага бусад удирдлагын түвшинд ухуулан ойлгуулах болон танилцуулга материал тараах зэрэг арга хэмжээ авах, үр нөлөөтэй, үр ашигтай мэдээллээр хангаж албаны үнэ цэнийг нэмэгдүүлэх.																	
5	Улсын салбарын дотоод аудитын чадавхийг бэхжүүлэх техникийн хамтын ажиллагааны төслийн хүрээнд боловсруулагдсан дотоод аудит хийх аргачлалыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах, хянах үе шатуудад нэвтрүүлэх. Холбогдох ажлын баримтуудыг хөтлөх.																	
6	Олон улсын мэргэжлийн практикийн хүрээний дагуу дотоод аудит гүйцэтгэхэд шаардлагатай ёс зүй, мэдлэг, ур чадваруудыг тодорхойлон, байгууллагын хүний нөөцийн бодлого, албан хаагчдын сургалтын жил бүрийн төлөвлөгөөнд тусгуулан батлуулж, хэрэгжүүлэх.																	

## III. ХАМРАХ ХҮРЭЭ,

Аудитын хамрах хүрээг нийслэлийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний байгууллагууд, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн үйл ажиллагааны хөтөлбөр, Эдийн засаг, нийгмийн зорилтуудаар тодорхойлно.

Аудитын хамрах хүрээг төлөвлөгөөт, ТЕЗ-ын зүгээс захиалах гэсэн 2 үндсэн хэсэгт хуваана.

Төлөвлөгөөт

- НЗД-ын хэрэгжүүлэг агентлагууд
- ОНӨТҮГ-ууд
- ОНӨААТҮГ-ууд
- Харьяа байгууллагууд

ТЕЗ-ын зүгээс захиалах

- Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн Эдийн засаг, нийгмийн зорилтуудын хүрээнд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилт
- Тусгай зориулалтын сан
- Тодорхой байгууллагын тодорхой үйл ажиллагаа



➤ Бусад

Эрсдэлийн үнэлгээ

Стратеги төлөвлөгөөг боловсруулах 4 дүгээр үе шатанд тодорхойлогдсон 1-3 дугаар түлхүүр алхамуудыг хэрэгжүүлэх, аудитын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөг боловсруулах үүднээс төлөвлөж болох хамрах хүрээний байгууллагуудын эрсдэлийг дараах ерөнхий 7 үзүүлэлтүүдээр харьцуулан үнэлнэ. Үүнд:

1. Төсөв, хөрөнгө оруулалтын төсвийн хэмжээ / Орлогын хэмжээ
2. Үр дүнгийн гэрээний үнэлгээ / Конрактын үнэлгээ
3. Тогтвортой байдал
4. Дотоод хяналтын тогтолцоо
5. Дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилт
6. Нийслэлийн Аудитын газрын дүгнэлт, зөвлөмж
7. Үйл ажиллагааны цар хүрээ

Дээрх үзүүлэлтүүдээр харьцуулан үнэлэхдээ доорх хүснэгтэд харуулсан шалгууруудыг ашиглан, эрсдэлийн тоон болон чанарын түвшин /нөлөөлөл/-ийг магадлалаар үржүүлж нийт оноогоор аудитын объектуудыг эрсдэлээр нь эрэмбэлнэ.

№	Магадлал	Эрсдлийн шалгуур үзүүлэлтүүд	Тоон түвшин	3	2	1
			Чанарын түвшин	Их	Дунд	Бага
1	2	Төсөв, хөрөнгө оруулалтын төсвийн хэмжээ / Орлогын хэмжээ		2 тэрбумаас дээш	0.8 -2 тэрбум	0.8 тэрбум хүртэл
2	3	Үр дүнгийн гэрээний үнэлгээ / Конрактын үнэлгээ		80% хүртэл	80-90% хүртэл	90%-иас дээш
3	2	Тогтвортой байдал, хүний нөөцийн оролт, гаралт		Байгууллага шинээр үүсгэн байгуулагдсан эсвэл нийт хүний нөөцийн 30% буюу түүнээс дээш өөрчлөлттэй	Байгууллагад бүтцийн өөрчлөлт хийгдсэн, удирдлага солигдсон эсвэл нийт хүний нөөцийн 20-30% өөрчлөлттэй	Хүний нөөцийн өөрчлөлт 20% дотор
4	2	Дотоод хяналтын систем		Дотоод хяналтын ажилтангүй	Дотоод хяналтын ажилтан, албан хаагчтай	Дотоод хяналтын нэгжтэй, нэгжийн үйл ажиллагаа жигдэрсэн
5	3	Дотоод аудиын зөвлөмжийн хэрэгжилтийн байдал		70% хүртэл	70-85%	85-100%
6	1	НАГ-ын газрын дүгнэлт, зөвлөмж		Дүгнэлт өгөхөөс татгалзсан, сөрөг дүгнэлт	Хязгаарлалттай дүгнэлт	Зөрчилгүй
7	2	7. Үйл ажиллагааны цар хүрээ	Хэлтэс, албадын тоо	8-аас дээш	5 - 7	4 хүртэл
			Ажиллагсадын тоо	100-аас дээш	31 - 100	30 хүртэл

Аудитын төрөл

Нийслэлийн Дотоод аудитын алба нь дараах аудитын төрлүүдийг гүйцэтгэнэ. Үүнд:

- Санхүүгийн аудит, хяналт шалгалт
- Гүйцэтгэлийн аудит

- Нийцлийн аудит
- Бусад

Дээрх аудитын төрлүүд нь зорилго, чиг үүргийн хувьд харилцан адилгүй бөгөөд нийслэлийн Дотоод аудитын албаны Санхүүгийн аудитын хэлтэс, Гүйцэтгэл, нийцлийн аудитын хэлтсийн аудитын хамрах хүрээ төлөвлөгөөт объектуудын хувьд өөр, өөрөөр тодорхойлогдох ба энэ нь албаны дотоод аудитын дунд хугацааны болон жилийн төлөвлөгөөг боловсруулахад харгалзан үзэх нөхцлүүдийн нэг болно.

Мөн аудитын дунд хугацааны төлөвлөгөө түүнд үндэслэсэн аудитын жилийн төлөвлөгөөг боловсруулахад дараах нөхцлүүдийг уялдуулна. Үүнд:

1. ТЕЗ-ын зүгээс захиалан гүйцэтгүүлэх аудитын тоог өмнөх жилүүдийн үзүүлэлт болон ирээдүйн төсөөллөөр ойролцоолон гаргаж, төлөвлөгөөт аудитын тоотой харьцуулах.
2. Дотоод аудитын үйл ажиллагаа нь төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах, хянах гэсэн 4 үе шатыг зайлшгүй хэрэгжүүлэх ба тус бүрт ногдох хугацааг нарийн тодорхойлох.
3. Албаны хэмжээнд аудит хийх боломжтой дотоод аудиторуудын тоог харьяалагдах хэлтсийн болон тэдгээрийн ажлын үндсэн чиг үүрэг, мэдлэг, ур чадвар зэргээр нь тодорхойлох, мөн тэдгээрийн тухайн жилд ноогдох нийт хүн өдрийг тооцож харгалзуулах.
4. Дотоод аудиторуудын 1 жилд нийт хэдэн аудитыг гүйцэтгэвэл ажлын үр дүн, ачааллын хувьд хамгийн тохиромжтой болох, эсвэл 1 аудитыг хэдэн хүн өдөрт хийх нь үр дүнтэй байх талаар дундажилж тооцож үзэн, уялдуулах.

ХЯНАН БАТАЛСАН:

НИЙСЛЭЛИЙН ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Б.ЖАВЗАН

БОЛОВСРУУЛСАН:

ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХЭЛТЭС  
АХЛАХ ШИНЖЭЭЧ  
АУДИТОР

Ц.БОЛДБААТАР

Б.УРАНБИЛЭГ